



**SoftPay**



## “ITGEL MM” v 1.5 Softpay



TranzWare ISO 8583 Terminal Protocol (TITP), v.2.51.

TranzWare Онлайн системийн хувилбар 5.1.30.4.F6 стандартын дагуу боловсруулсан.

ECR-тай шууд холбогдон ажиллана.

NFC –г дэмжинэ.

## ИТГЭЛ ММ V. 1.5 SOFTPAY

### Стандарт үзүүлэлтүүд

<b>Үйлдлийн систем</b>	Verix Evo
<b>Стандарт</b>	ISO 8583 FCC/CE/CCC, PBDC& EMV 1, 2
<b>Нэмэлт төхөөрөмж</b>	ECR(холбогдох боломжтой)
<b>Холболт</b>	Wi-fi, 3G, Ethernet
<b>Хамгаалалт</b>	PCI-PED 3.0
<b>Картын систем</b>	BPC-SMART VISA IPS /VISA MASTER CARD Сертификат
<b>Протокол</b>	TITP V.2.51
<b>Хэлний тохиргоо</b>	Англи, Монгол

## Давуу болон ашигтай тал

- Худалдан авахад үнийн хувьд хямд, боломжийн нэг ПОС дээр 30 ам доллар
- ECR протоколын дагуу кассын машинтай холбогдон ажилладаг. ECR нь хоёр төхөөрөмжийн хооронд мэдээлэл солилцох стандарт протокол юм.



Монгол инженер програмистуудын зохион бүтээсэн програм хангамж Гадагш урсах мөнгийг эх орондоо үлдээнэ Програм хангамжид хийгдэх үйлчилгээ болон засварлалт түргэн шуурхай

## Үйл ажиллагааг хэмнэх

- ПОС удирдлагын систем болох Веричентр 3.0 програмтай холбогдон ажиллах боломжтой. ПОС терминал нь тус удирдлагын системтэй холбогдон ажилласнаар үйлдлийн систем (OS), нэмэлт үйлдлийн систем (EOS), NFC-н нэмэлт сан (CTLS), банкны програм хангамжийн (Application) нэмэлт өөрчлөлтийг (update) автоматаар суулгах боломжтой. Ингэснээр хэд хэдэн инженер техникийн ажилчдын ажлыг хөнгөвчилнө.




- Соронзон, EMV болон Контактлес карт уншина.
- Нэг ПОС дээр 1-5 хүртэл мерчантыг бүртгэн ажиллуулах боломжтой.
- Нэг ПОС-оос 1-8 хүртэл хост уруу хандан, ялгаатай форматтай (spec) мэдээлэл дамжуулах боломжтой. Тухайн картын BIN Range-с хамааран өөр өөр хост руу хандана.

## Тогтвортой байдал

- ПОС терминалын хөгжил өндөр хурдацтай явагдаж байгаатай уялдуулан инженер техникийн ажилчид байнга мэргэжил дээшлүүлэн суралцдаг. Тухайн програм хангамжийг 3-4 хүний бүрэлдэхүүнтэй програмын хангамжийн хэлтэс тогтвортой байнгын үйл ажиллагаатай хөгжүүлэн авч явдаг.




Картаа шургуулах



Картаа зурж уншуулах  
Дээрээс доош нь картаа татна.

# Softpay Итгэл ММ пос программын үндсэн цэс



## Softpay ИТГЭЛ ММ v.1.5 пос программын нэмэлт цэс







## Purchase/Худалдан авалт/

Энэ цэс нь санхүүгийн гүйлгээ хийхэд ашиглагдах бөгөөд хийгдсэн гүйлгээ бүр нь терминал дээрх нэгдсэн дүнд тусгагдана.

1. Үндсэн цэснээс **PURCHASE** цэсийг сонгоно.
2. Дараах харилцах цонх гарч ирэх ба Картаа уншуулна (картаа зурах эсвэл шургуулах).
3. Гүйлгээний мөнгөн дүнг оруулсаны дараа Пин кодыг оруулснаар гүйлгээ хийгдэнэ.
4. Гүйлгээ хийхэд баримт нь автоматаар төхөөрөмжөөс хэвлэгдэнэ.

5







## Balance /Үлдэгдэл/




Картны үлдэгдлийг мэдээлэх ба гүйлгээний хариу мэдээлэл төхөөрөмжөөс хэвлэгдэнэ.


1. Үндсэн цэснээс **BALANCE** цэсийг сонгохын тулд #6 товчгыг дарна.

2. Дараах харилцах цонх гарч ирэх ба картаа уншуулна.

3. Пин кодыг оруулна.

4. Картны үлдэгдлийн баримт төхөөрөмжөөс хэвлэгдэнэ.






## Void /Буцаалт/

Терминалаар хийсэн гүйлгээг цуцлах талаар банкинд мэдэгдэн гүйлгээг хүчингүй болгоход хэрэглэгдэнэ.


1. Үндсэн цэснээс **VOID** цэсийг сонгоно.


2. Дараах харилцах цонх гарч ирэх бөгөөд тухайн гүйлгээний нэхэмжлэх дугаарыг оруулна.



3. Дэлгэц дээр тухайн гүйлгээний товч мэдээлэл гарч ирэх ба гүйлгээг цуцлах, эсвэл цуцлахгүйг сонгоно. “тийм” “үгүй” гэсэн 2 сонголтоос сонгоно. Гүйлгээг цуцлах бол “тийм”, цуцлахгүй бол “үгүй” цонхыг дарна.

4. Гүйлгээг цуцлах бол “тийм” гэж дарахад төхөөрөмжөөс гүйлгээ цуцалсан баримт хэвлэгдэнэ.





## Check connection /Сүлжээ шалгах/

Энэ нь терминал сүлжээнд холбогдож буй эсэхийг шалгахад хэрэглэнэ.


1. Үндсэн цэснээс **check connection** цэсийг сонгохын тулд #7 товчыг дарна.
2. Дараах харилцах цонх гарч ирэх ба сүлжээний шалгах процессыг харуулна.




## Settlement/Нэгтгэл/

Тухайн арилжаалагчийн харилцсан үйлчлүүлэгчдийн нийт санхүүгийн гүйлгээг хөрөнгийн эх үүсвэр болох төв рүү мэдээллэхэд энэ цэсийг ашиглана.

1. Үндсэн цэснээс **SETTLEMENT** цэсийг сонгоно.
2. Дараах харилцах цонх гарч ирэх ба цонхонд тухайн өдрийн гүйлгээний мэдээлэл гарч ирнэ.




3. Бүх гүйлгээг нэгтгэн дүгнэж тооцоолох бол даран  баталгаажуулна.
4. Баталгаажсан бол төхөөрөмжөөс автоматаар гүйлгээг нэгтгэн дүгнэсэн баримт хэвлэгдэнэ.



## Reprint /Баримт дахин хэвлэх/

Гүйлгээний баримтыг дахин хэвлэхэд хэрэглэнэ.


1. Үндсэн цэснээс **REPRINT** цэсийг сонгоно.
2. Дараах харилцах цонх гарч ирэх ба Уг цонхонд :
  - сүүлийн баримт хэвлэх
  - нэгтгэл баримт хэвлэх
  - аль нэг баримтыг хэвлэх гэсэн 3 сонголт гарч ирнэ.
3. Сонгосон тухайн баримт төхөөрөмжөөс хэвлэгдэнэ.



## Reports /Тайлан/

Энэ нь тухайн төхөөрөмжинд хийгдсэн санхүүгийн гүйлгээг мэдээлэх зориулалттай.

1. Үндсэн цэснээс **REPORTS** цэсийг сонгоно.
2. Дараах харилцах цонх гарч ирэх ба Уг цонхонд :
  - Хураангуй тайлан
  - Дэлгэрэнгүй тайлан гэсэн 2 сонголт гарч ирнэ.
3. Тухайн сонгосон гүйлгээний тайлан төхөөрөмжөөс хэвлэгдэнэ.





### Batch totals /Багцын дүн/

Тухайн ПОС төхөөрөмжөөр хийсэн худалдааны мөнгөн гүйлгээ болон буцааж хийсэн шилжүүлгийн нэгдсэн дүнг багцлан харуулна. Хариу мэдээлэл дэлгэцэн дээр гарч ирнэ.

1. Үндсэн цэснээс **BATCH TOTALS** цэсийг сонгоно.

2. Дараах харилцах цонх гарч ирнэ.

3. Сонгосон тухайн банкны орлого, зарлагын гүйлгээний мэдээллийг багцлан дэлгэцээр харуулна.



### Batch review / Багцын үнэлгээ/



Тухайн ПОС төхөөрөмжөөр хийсэн худалдааны мөнгөн гүйлгээ болон буцааж хийсэн шилжүүлгийг ерөнхий байдалаар харуулна. Хариу мэдээлэл дэлгэцэн дээр гарч ирнэ.

1. Үндсэн цэснээс **BATCH REVIEW** цэсийг сонгоно.

2. Нууц үгээ оруулсны дараа дараах харилцах цонх гарч ирнэ.

3. Тухайн гүйлгээний холбогдох мэдээллийг сонгоно.

4. Сонгосон тухайн гүйлгээний мэдээллийг дэлгэцээр харуулна.







### Download KEYS /Түлхүүр татах/

Энэхүү цэс нь таньд working key татах боломжыг олгоно.


1. Үндсэн цэснээс **Download KEYS** цэсийг сонгоно.
2. Нууц үгээ оруулна.



### Download EWK /EWK Татах/

Энэхүү цэс нь таньд traffic encryption key татах боломжыг олгоно.

1. Үндсэн цэснээс **Download EWK** цэсийг сонгоно.
2. Нууц үгээ оруулна.



## Setup / Тохиргоо /

ПОС төхөөрөмжинд тохиргоо хийх.

1. Үндсэн цэснээс **SETUP** цэсийг сонгоно.

2. Дараахи харилцах цонх гарч ирнэ. Уг цонхонд:

- Хэвлэлийн тохиргоо /Print Config/
- Устгалыг цэвэрлэ /Clear Reversal/
- Терминал /Terminal/
- Түлхүүрийн тохиргоо хийх /Edit DCT/
- Үйлдэл /Comm/
- Хүлээн авагчыг засварлах /Edit Acquirer/
- Картыг засварлах /Edit Cards/
- Банк /Host/- Холбогдох банкыг мэдээлэлийг өөрчлөх.

- Хост IP засварлах /Edit Host IP/- Тухайн холбогдох банкны өөрчлөх.

- Мастер түлхүүр оруулах /Inject TMK Key/

- Багцыг устгах /Clear Batch/ - Хадгалагдсан багцыг устгах.

- Хадгалагдсан /Reserved/




- Хэлийн тохируулах /Language Settings/-Англи, Монгол хэл.

- Тухай /About/ - Тухайн пос-н товч мэдээлэл.

- Контактлесс түлхүүр оруулах /Inject CTLS Key/

- Скриптийг шинэчлэх /Update Script/ -CTLS тохиргоог өөрчлөх гэсэн сонголтууд гарч ирнэ.


3. Хийх тохиргоог сонгоно.






**Clear reversal /Цуцлагдсан гүйлгээний мэдээллийг устгах/** - энэ цэсийг пос төхөөрөмж дээр автоматаар хадгалагдсан, цуцалсан болон хүчингүй болсон гүйлгээнүүдийн мэдээллийг устгахад хэрэглэнэ.

1. Үндсэн цэснээс **SETUP** цэсийг сонгоно.
2. **CLEAR REVERSAL** цэсийг сонгоно.
3. Дараах харилцах цонх гарч ирнэ.
4. Холбогдох банкаа сонгоно.
5. Цуцалсан гүйлгээг устгахыг баталгаажуулахдаа “тийм” “үгүй” гэсэн сонголтоос сонгоно.




**Terminal /Терминал/** - энэ цэсийг пос төхөөрөмж дээр хадгалагдсан өгөгдөлийг тохируулахад хэрэглэнэ.

1. Үндсэн цэснээс **SETUP** цэсийг сонгоно.
2. **TERMINAL** цэсийг сонгоно.




3. Дараах харилцах цонх гарч ирнэ.
4. Холбогдох терминалыг сонгох.
5. Өөрчлөх гэж буй өгөгдөлөө сонгоод тухайн мэдээллийг засварлана.





**Command /Үйлдэл/** - энэ цэсийг пос төхөөрөмжийн үйлдэл буюу командыг тохиргоог өөрчилж тохируулахад хэрэглэнэ.

1. Үндсэн цэснээс **SETUP** цэсийг сонгоно.
2. Command цэсийг сонгоно.
3. Дараах харилцах цонх гарч ирнэ.
4. Өөрчлөх гэж буй өгөгдөлөө сонгоод шинэ мэдээлэлийг оруулна.



**Edit acquirer /Хүлээн авагчийг засварлах/** - энэ цэсийг пос төхөөрөмж дээр хадгалагдсан хүлээн авагчийн мэдээлэлийг тохируулахад хэрэглэнэ.

1. Үндсэн цэснээс **SETUP** цэсийг сонгоно.
2. EDIT ACQUIRER цэсийг сонгоно.
3. Дараах харилцах цонх гарч ирнэ.
4. Холбогдох дугаарыг сонгох.
5. Өөрчлөх гэж буй өгөгдөлөө сонгоод доторх мэдээллийг засварлана.

# *Хамтдаа хөгжицгөө*



**SoftPay**

**“Итгэл ММ” програмын 1.5 хувилбар**

**ММ СИСТЕМС ХХК.**